



БНМАУ

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ  
ТОГТООЛ

1989 оны 7 сарын 31 өдөр

дугаар 160

Улаанбаатар хот

Ясли татан буулгах, шилжүүлэн ажиллуулах тухай

Улсын барилгын шалган байцаах газрын 1989 оны 3/25, 3/29 тоот дүгнэлт, болон Сэтгэл мэдрэлийн өвчнийг анагаах клиникийн эмнэлгийн дэргэд 280 ортой ясли-цэцэрлэгийн комбинат барих талбайд 10 дугаар яслийн барилга байрлаж байгааг харгалзан Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Энэ оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн Найрамцлын районы 10, Сүхбаатарын районы 24 дүгээр яслиудыг татан буулгасугай.

2. Эцгээр яслиудац явж байгаа хүүхдүүдийг дэргэдэх 3,109-р ясли-цэцэрлэгийн комбинатуудац болон бусад яслиудац шилжүүлэн зохицуулах арга хэмжээ авахыг Хотын ардын боловсролыг уцирдах газар/н.Батмагнай/, Эрүүлийг хамгаалах газар /н.Бямбаа/-т даалгасугай.

3. Улаанбаатар хотын эрүүлийг хамгаалах газар /н.Бямбаа/-т ДААЛГАХ нь:

а/10,24 дүгээр яслиудын хуучин барилгыг зохих журмын дагуу актлаж устгах, засварлаж өөр зориулалтаар ашиглах эсэхийг шийдвэрлэх.

б/ээрмэлийн үйлдвэр, хотын барилга засварын нэгдсэн трестийн хүсэлтийг үндэслэн тэдний гаргаж өгсөн байранд 12 цагаар ажиллах тус бүр 30 ортой 10,24-р яслийг шинээр байгуулан татан буугдсан цээрхи яслиудын төсөв, орон тоог 1989 оны III улирлаас эхлэн шилжүүлэн ажиллуулах.

2.

4.Энэ арга хэмжээтэй холбогдуулан яслиудын төсөв, төлөвлөгөө хүнсний хуваарьт зохицуулалт хийж өгөхийг Хотын санхүүгийн хэлтэс /н.Гонгор/, Төлөвлөгөөний комисс /н.Бат/-т цаалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРГААНЫ ДАРГА,

*[Handwritten signature in black ink]*

С.МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН  
БАЧГИЙН ДАРГА

*[Handwritten signature in blue ink]*

Д.АЛТИА